



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Дэд ажлын хэсэг байгуулах тухай

1.Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 91 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэр дэх Оросын Холбооны Улсын зарим үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх, хамаарал бүхий газрын ашиглах эрхийг бүртгэх нөхцөлийн тухай Оросын Холбооны Улс, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийн хавсралтыг бэлтгэх, газар ашиглах эрх болон үл хөдлөх хөрөнгийг Улсын бүртгэлд бүртгэхэд шаардагдах баримт материалыг бүрдүүлэх ажилд Оросын Холбооны Улсын талын ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий дэд ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Дэд ажлын хэсгийн
ахлагч

Барилга, хот байгуулалтын яамны Хот
байгуулалт газрын харилцааны бодлогын
хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах
шинжээч Г.Болормаа

Гишүүд:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд
хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга
Б.Ариунболд

Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн
газрын кадастрын хэлтсийн дарга Б.Баянтүмэн

Нийслэлийн Газар зохион байгуулалтын
газрын орлогч дарга Б.Загдсамбар

Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн
газрын орлогч дарга Ч.Бум-Эрдэнэ

Нарийн бичиг:

Гадаад харилцааны яамны Олон улсын
гэрээ, эрх зүйн газрын атташе А.Баярсайхан

2.Оросын Холбооны Улсын талын дэд ажлын хэсэгтэй хамтран ажиллахыг
дэд ажлын хэсгийн ахлагч Г.Болормаад үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132005094

ТӨБЗГ тушаал-/2022